



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/449

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2.в, 29.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн үйлчилгээг шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор өрх, хүн амын тоо, газар нутгийн хэмжээг харгалзан Дүүргийн 3,4,6,7,8,17,18,20 дугаар хороодыг шинэ зохион байгуулалтад оруулах, хилийн цэсийг шинэчлэн тогтоох санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Дүүргийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Б.Мөнгөнхуяг	(Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)
Нарийн бичгийн дарга:	Н.Анхбаяр	(Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хороо хариуцсан мэргэжилтэн)
Гишүүд:	Б.Лхагвабаатар	(Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт шинжилгээний хэлтсийн дарга)
	Г.Чинжаргал	(Статистикийн хэлтсийн дарга)
	Д.Энхтөр	(Газар зохион байгуулалтын албаны дарга)
	Ч.Мандалмаа	(Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)

2.Дээрх ажлын хэсгийн ажлыг зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг Тамгын газар (Б.Нарангэрэл)-т даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засаг, худалдаа үйлчилгээ, тохижилт нийтийн аж ахуйн асуудал хариуцсан төслийн удирдагч (Д.Мөнхбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ө.СУМЪЯАБААТАР

